

**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ**

| Д/д | Үзмэрийн нэр  | Хувийн дугаар | Тоо ширхэг | Хэмжээ                     | УБМС-ийн дугаар РСН (программын) | Судлагдсан сурталчлагдсан байдал  | Саналын үндэслэл   |
|-----|---------------|---------------|------------|----------------------------|----------------------------------|---|--|
| 1   | Нийслэл хүрээ | УБМ74.2<br>3  | 1          | Урт-282см,<br>Өргөн- 148см | 1110УБМ703                       | <p>- Пүрэв, О. <i>Монгол төрийн голомт</i>, Улаанбаатар: 2004, 9-11, 36-38, 66, 90-93, 104</p> <p>- Саруулбуян, Ж. <i>Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэр болоод түүний бүтээсэн Нийслэл хүрээ зургийн тухай</i>, Нийслэл хүрээ 100 жил, эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Улаанбаатар: 2012, 107-125</p> <p>- Очбаяр, Г. <i>Богдын ордны алдарт зураач Жүгдэрийн “Нийслэл хүрээ” зураг</i>, Нийслэл guide сэтгүүл, 2014, №31, тавдугаар сар, 50-53.</p> <p>- Доржготов, О. <i>Бурхач Жүгдэрийн “Нийслэл хүрээ” зургийн зохиомж дүрслэлийн онцлог</i>, ШУА, ФСЭЗХүрээлэн “Эрдмийн ертөнц” эрдэм шинжилгээний бичиг, 2012, 144-151</p> <p>- Нацагдорж, Н. Очбаяр, Г. <i>Улаанбаатар хотын барилгажилтын түүх, гэрэл зургийн цомог</i>, Улаанбаатар: 2014, 24, 34, 38-39, 51, 54-55.</p> <p>- Очбаяр, Г. Цацралт, С. <i>Чингэлтэй хайрханы өвөрт, гэрэл зургийн цомог</i>, Улаанбаатар: 2015, 11, 16-17, 18, 20-21, 32, 55, 78, 109.</p> <p>- <i>Зураг болгомооргүй түүх (тусгай дугаар)</i>, Үндэстний тойм сэтгүүл, №6 (157) 2013.02.11, 1-51.</p> | <p>XX зууны эхэн үеийн Монгол Улсын хамгийн том хот Нийслэл хүрээг монгол уран зургийн тэгээр зурсан бүтээл бол Жүгдэрийн зурсан Нийслэл хүрээ хэмээх зураг юм. Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэрийн 1910-аад оны үед зурсан Нийслэл хүрээ зураг өдгөө Богд хааны ордон музейд эх хувиараа хадгалагдаж байгаа бөгөөд хожим буюу 1946 онд БНМАУ-ын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, уран зураач Д.Манибадар уг зургийг томруулан хуулбарлаж зурахдаа тухайн үеийн хүрээний аж амьдралыг баяжуулан зурсан нь өдгөө Улаанбаатар хотын музейд хадгалагдаж байна. Энэхүү бүтээлд 1910-аад оны Нийслэл хүрээний бүтэц, зохион байгуулалт, төрх байдал, бүлэг давхаргын ялгаа, амьдралын хэв маягийг бодитоор харуулдаг бөгөөд өдгөө XX зууны эхэн үеийн Монгол Улсын нийслэл хотын төрх байдлыг бодитоор харуулсан урлаг, зурагзүйн бүтээл төдийгүй түүхийн эх сурвалж болж байгаа учраас тус дурсгалыг үнэт үзмэрт нэр дэвшүүлж байна.</p> |

|   |                                     |              |   |                                       |            |  |   |
|---|-------------------------------------|--------------|---|---------------------------------------|------------|--|---|
|   |                                     |              |   |                                       |            | <p>- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II, Улаанбаатар: 2014, 134</p> <p>- 2020.11.15 – Гэрээсээ музейд: Улаанбаатар хотын музейн онцлох таван үзмэр, ikon.mn</p> <p>- 2022.10.30-2022.11.01 - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Хүндэтгэлийн хурал”-ын үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2023.04.20 – Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар өнгөрсөн ба одоо” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнд тавигдсан.</p> |   |
| 2 | Сувдан чимэгтэй зээгт наамал бурхан | UBM61.6<br>8 | 1 | Өргөн:<br>71.5см,<br>Өндөр:<br>91.5см | 1110УБМ200 | <p>- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II, Улаанбаатар: 2014, 132</p> <p>- Лхагвасүрэн, Б. Лонжид, З. Монгол Улсын хосгүй үнэт үзмэрийн дээжис, Улаанбаатар: 2020, 359</p> <p>2008.03.10- 2008.10.07 СӨҮТ-д сэргээн засварлуулсан.</p>   | Торгон зураг буюу зээгт наамлын урлаг нь Хүннү нарын үеэс улбаатай бөгөөд бурхны шашин дэлгэрэхэд тусгай нэгэн төрөл урлал болон хөгжсөөр XIX зуунд оргил үедээ хүрчээ. Тус зээгт наамалд Өндөр гэгээн Занабазарын өөрийн мутраар урласан “Долоон нандин” шүтээний нэг болох Очирдара бурхныг дүрсэлжээ. Очирдара бурхан нь Богд Жэвзүндамба хутагтуудын гол шүтээн байсан бөгөөд одоог хүртэл Гандантэгчэнлин хийдийн Батцагаан дуганы гол шүтээн хэвээр байна. Энэхүү бүтээл нь XX зууны эхэн үеийн монгол урчуудын ур ухааныг харуулсан бүтээл бөгөөд байгалийн шүр сувдаар гоёсон маш нарийн ур хийцтэй, “Хүрээ урлал”-ын торгон зургийн шилдэг |

|   |                                     |         |   |   |            |  |  |
|---|-------------------------------------|---------|---|---|------------|--|--|
|   |                                     |         |   |   |            |  | бүтээлийн нэг учраас тус дурсгалыг үнэт үзмэрт нэр дэвшүүлж байна.   |
| 3 | Л.И.Брежнев                         | UBM82.2 | 1 | Өргөн: 68см,<br>Өндөр:<br>125.4см                               | 1110УБМ199 | Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II, Улаанбаатар: 2014, 137   | 1981 онд Зөвлөлтийн удирдагч Леонид Ильич Брежнев БНМАУ-ын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнагдахад түүнд зориулан уг бүтээлийг БНМАУ-ын Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, нэрт уран хатгамалч А.Цэрэнхүү 1982 онд тус торго, даавуу, зэс утсаар бүтээжээ. Уг хатгамалд ЗСБНХУ-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Леонид Ильич Брежневийг амьд мэт тод томруун, уран нарийн оёж, уран зураг шиг дүрслэлийн ялгарлыг нарийн гарган хийсэн нь энэхүү бүтээлийг Монголын орчин үеийн уран хатгамлын урлагийн шилдэг бүтээлийн нэг болгосон байна. Энэхүү бүтээл нь А.Цэрэнхүүгийн уран хатгамлын оргил бүтээлийн нэг юм. |
| 4 | Улаанбаатар хотын төв хэсгийн макет | UBM76.7 | 1 | Өргөн: 406см,<br>Өндөр: 180см                                   | 1110УБМ566 | - Болдбаатар, Ч. Очбаяр, Г. Одсүрэн, О. Монгол Улс Нийслэл Улаанбаатар он дарааллын бичиг, Улаанбаатар: 2023, 138<br>- Нацагдорж, Н. Очбаяр, Г. Улаанбаатар хотын барилгажилтын түүх, Улаанбаатар: 2014, 152-167<br><br>- 2020.11.15 – Гэрээсээ музейд: Улаанбаатар хотын музейн онцлох таван үзмэр, ikon.mn | ЗХУ-ын Гипрогор институтын боловсруулсан Улаанбаатар хотыг хөгжүүлэх III ерөнхий төлөвлөгөөг 1976 онд Сайд нарын Зөвлөлөөс баталжээ. Тус төлөвлөгөөг биетээр жижигрүүлэн харуулсан макетыг Улаанбаатар хотын Хот төлөвлөлтийн алба хариуцан хийсэн байна. Эдүгээ уг модон макет нь Социализмын үеийн Улаанбаатар хотыг хөгжүүлэх дөрвөн ерөнхий төлөвлөгөөнөөс хадгалагдан үлдсэн цор ганц биет бүтээл юм.   |
| 5 | Занабазар                           | UBM65.1 | 1 | Урт: 48см,<br>Өргөн: 48см,<br>Өндөр:<br>68.5см, Жин:<br>25360гр | 1110УБМ212 | - Болдбаатар, Ж. Уран Жамбаа, Улаанбаатар: 2006, 40, 60<br>- Туул, Н. Анхбаяр, Д. Нийслэл хүрээ-110 жил үзэсгэлэн, Улаанбаатар: 2023, 7  | Тус баримлыг Монгол Улсын ардын зураач, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Монголын орчин үеийн анхны барималчдын нэг, олны дунд “Уран” хэмээн алдаршсан Нямын Жамбаа 1955 онд бүтээжээ. Завилгаа суудалтай, баруун гарын бугуйнд эрх,  |

|   |                                |                |   |   |            |   |   |
|---|--------------------------------|----------------|---|---|------------|---|---|
|   |                                |                |   |   |            | <p>- 2012 – Монголын үндэсний музейд дэглэсэн “Нийслэл хүрээ-100 жил” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2022.01.31-2022.02.25 – Монголын үндэсний музейд дэглэсэн “Нийслэл хүрээ 110 жил” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2020.11.15 – Гэрээсээ музейд: Улаанбаатар хотын музейн онцлох таван үзмэр, ikon.mn</p>  | <p>зүүн гартаа соёмбо барьсан байдалтайгаар анхдугаар Богд Занабазарыг дүрсэлсэн энэхүү баримлыг судлаачид Занабазарын дүр төрхийг хамгийн бодитой гаргасан орчин үеийн бүтээл гэж үнэлдэг.</p>   |
| 6 | Ломбардын бичиг                | УВМ60.6        | 1 | Урт: 23.2см,<br>Өргөн: 23см   | 1110УБМ298 | <p>- Одсүрэн, О. Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй “Ломбардын бичиг” үзмэрийн тухай, Музей судлал, Том XXIII, Fas. 1-21, Улаанбаатар: 2022, 52-69</p> <p>- 2022.10.30-2022.11.01 - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Хүндэтгэлийн хурал”-ын үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнд тавигдсан.</p> | <p>1924 онд Улаанбаатар хотын захиргаанд байгуулагдсан шинэ үйлчилгээний нэг нь Ломбард буюу Барьцаалан зээлдүүлэх газар байв. Энэхүү Ломбардын газрын үйл ажиллагаатай холбоотой цор ганц бүртгэлийн дэвтэр эдүгээ Улаанбаатар хотын музейд хадгалагдаж байна. Ломбардын газарт эд хөрөнгөө барьцаанд тавьж байсан иргэдийн мэдээлэл, тухайн үеийн барьцаалан зээлдүүлэх газрын хүү, мөнгөн дүнгийн талаар мэдээлэл агуулсан баримтат өв нь ломбард, түүгээр үйлчлүүлэгчийн хоорондын харилцааг гэрчилсэн, эдүгээ маш ховорт тооцогдох түүхэн эх сурвалж, баримт юм.</p> |
| 7 | 12 жилтэй янтай, жижиг цоожтой | УВМ61.3<br>3-2 | 2 | Урт: 8.9см,<br>Өргөн: 5.6см,<br>Жин: 190гр,<br>Зузаан: 2.9см,<br>Хэмжээ:<br>2/Цоож У 1.9 см, Өр 1.7 см,<br>Зу 1.1 см, жин 14 гр | 1110УБМ153 | <p>- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II, Улаанбаатар: 2014, 122</p> <p>- Туул, Н. Анхбаяр, Д. Нийслэл хүрээ-110 жил үзэсгэлэн, Улаанбаатар: 2023, 48</p> <p>- 2022.01.31-2022.02.25 – Монголын үндэсний музейд дэглэсэн “Нийслэл хүрээ 110 жил” үзэсгэлэнд тавигдсан.</p>   | <p>Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй уг янтай, цоож нь XX зууны эхэн үеийн Хүрээний уран дархчуудын урласан сор бүтээлийн нэг юм. Янтайн дээд хэсгийг арван хоёр жилийн амьтнаар хүрээлж, түүний дотор талд дөрвөн хүчтэн, эвтэй дөрвөн амьтныг сийлж шармалдан, савны хоёр хажуу талыг цэцгэн хээ угалзаар чимэглэн өнгө зохилдлого, хийц загварыг нарийн гаргаж өгчээ. Цоожны нүүрэн хэсэгт товойлгон гаргаж шармалдсан</p>  |

|   |                   |         |   |                              |            |   |  |
|---|-------------------|---------|---|------------------------------|------------|---|--|
|   |                   |         |   |                              |            | <p>- 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнд тавигдсан.</p>   | <p>арслангийн дүрстэй. Янтай нь бичиг, номын хүмүүсийн хэрэглэдэг хүмүүсийн бэх хийх зориулалт бүхий сав юм. Янтайн цоож нь монголын музейнүүдэд хадгалагдаж буй хамгийн жижиг цоож юм.</p>  |
| 8 | Түүхт Улаанбаатар | UBM74.2 | 1 | Урт: 161см,<br>Өргөн: 12.6см | 1110УБМ191 | <p>- Бат-Очир, Р. <i>Урчуудын тухай тэмдэглэл</i>, Улаанбаатар: 1984<br/> - Даваадаш, Н. <i>Өврийн хангайн зураач, урчуудын товчит</i>, Улаанбаатар: 2014, 192-193<br/> - Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. <i>Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II</i>, Улаанбаатар: 2014, 137<br/> - МҮОНРТВ “<i>Бөхийж үзээгүй далбаа</i>” баримтат нэвтрүүлэг<br/> - Соёлын Өвийн төвд 2008 онд сэргээн засварлуулсан.</p> <p>- Уран сайхны фондын хорооны тэргүүлэгчдийн 1974 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 8/4 дугаар хурлын тогтоолын хавсралт №1-д 1-р байранд С.Сэнгээгийн “Түүхт Улаанбаатар” сийлбэр нь бусад 16 бүтээлийн хамт шалгарч 5000 төгрөгөөр үнэлэгдсэн байна.</p> <p>- 1999.10.26 – Нийслэлийн 360 жилийн ойд зориулсан музейнүүдийн шилмэл үзмэрийн үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2004 – Улаанбаатар хотын 365 жилийн зориулсан үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2009.10.19-2009.11.05 – Монголын үндэсний музейд дэглэсэн Нийслэл Улаанбаатар</p> | <p>Тус дурсгалыг БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хотын 50 жилийн ойд зориулж БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн, чимэглэлийн урлагийн нэрт зүтгэлтэн, том хэмжээний ясан сийлбэрийн урлагийг Монгол Улсад тэргүүлэн хөгжүүлэгч С.Сэнгээ 1974 онд зааны соёон дээр сийлж бүтээжээ. Тус бүтээлд тухайн цаг үеийн Улаанбаатар хотын барилга, архитектур, хөшөө баримал, түүх, соёлын дурсгалыг дүрсэлж, түүгээр дамжуулж хотын хөгжил дэвшлийг харуулахыг зорьсон байна. Уг бүтээл нь зааны соёон дээр Улаанбаатар хотын барилга, архитектурыг цогцоор сийлсэн цор ганц бүтээл юм. Бүтээлийн уран нарийн хийц, загвар зохиомж, ашигласан материал зэргийг үндэслэн үнэт үзмэрийн саналд дэвшүүлж байна.</p> |

|                           |                                    |         |   |   |            |  |   |
|---------------------------|------------------------------------|---------|---|---|------------|--|---|
|                           |                                    |         |   |   |            | хот үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойн үзэсгэлэнд тавигдсан.  |   |
| 9                         | Улаанбаатар хотын захиргааны тамга | UBM64.4 | 1 | Урт: 6.9см,<br>Өргөн: 6.8см,<br>Өндөр: 6.7см,<br>Жин: 830гр,<br>Зузаан: 1.9см | 1110УБМ368 | <p>- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II, Улаанбаатар: 2014, 123</p> <p>- 2009.10.19-2009.11.05 – Монголын үндэсний музейд дэглэсэн Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойн үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2013.10.26 – Нийслэлийн архивын газарт дэглэсэн “Нийслэл хүрээ 100 жил” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2018.07.06-07.08 – Сүхбаатарын талбайд дэглэсэн “Мөнх тэнгэр Монгол туургатны их наадам” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2022.10.30-2022.11.01 - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Хүндэтгэлийн хурал”-ын үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2023.04.20 – Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар өнгөрсөн ба одоо” үзэсгэлэнд тавигдсан.</p> <p>- 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнд тавигдсан.</p> | Улаанбаатар хотын захиргаа уг тамгыг 1932 оны 10 дугаар сарын 01-ээс 1937 оны 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэглэж байжээ. Тодруулбал, 1931 онд УБХ-ын Тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан шийдвэрээр Төв аймаг, Улаанбаатар хотын нутаг дэвсгэр, захиргааг нэгтгэн төвлөрүүлж, Улаанбаатар аймгийг байгуулжээ. Гэвч хот, хөдөөд явуулах ажил харилцан адилгүй тул тус шийдвэрийг жилийн дараа цуцалж, 1932 оны 10 дугаар сарын 01-ээс эхлэн Улаанбаатар хотын захиргааг дахин байгуулжээ. Хотын захиргааг дахин байгуулсантай холбогдуулан “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улаанбаатар хотын захиргааны тамга” хэмээн монгол бичгээр товойлгон бичсэн шинэ тамгыг хэрэглэж эхэлжээ. Улмаар 1937 оны 02 дугаар сарын 05-нд “Улаанбаатар хотын захиргааг яам болгох тухай” Засгийн газрын тогтоол гарч, хотын захиргааны нэр, статус өөрчлөгдсөнөөр уг тамгыг хэрэглэхээ больжээ. Энэхүү тамгыг 1932-1937 онд Улаанбаатар хотын даргаар ажиллаж байсан Д.Догсом, Д.Чимэддаваа нарын үед ашиглаж байжээ. |
| <b>9 ДЭСИЙН 10 ШИРХЭГ</b> |                                    |         |   |   |            |  |   |